

**ШУА-ИЙН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР (PhD),
ДЭД ПРОФЕССОР Д.ЗОЛБООГИЙН
ХУРЛЫГ ХААЖ ХЭЛСЭН ҮГ**

“Олон улс судлал 2020: Монголын хятад судлал” эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаа хөтөлбөрт заасан хугацаанаас бага зэрэг хоцорч өндөрлөж байгаад Та бүхнээсээ хүлцэл өчье. Гэвч манай өнөөдрийн эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд бүтэн өдрийн турш эхнээс нь дуустал идэвхтэй оролцсон эрдэмтэн судлаач, багш нартаа хүрээлэнгийнхээ нийт хамт олон болон хувийн зүгээс гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Мөн хурлын үйл ажиллагааны бэлтгэлийг амжилттай зохион байгуулсан доктор Д.Шүрхүү эрхлэгчтэй Хятад судлалын салбарын нийт ажилтнууддаа талархаж байна. Хөтөлбөрийн дагуу эрдэм шинжилгээний хурлын маань 4 салбар хуралдааны бүх оролцогчид илтгэлээ танилцуулж, үр өгөөжтэй хэлэлцүүлэг өрнөсөн гэдэгт бүрэн дүүрэн итгэлтэй байна. Эрдэм шинжилгээний хурлын илтгэгч, хэлэлцүүлэгт оролцсон эрдэмтдийнхээ хэлсэн үнэтэй санал зөвлөмжийг бид цаашдын үйл ажиллагаандаа тусган анхаарч ажиллах болно.

Хурлын өмнө та бүхэнд сонордуулсаны дагуу хурлын эмхэтгэл хэвлэгдэх учраас илтгэгч нарыг илтгэлээ болж өгвөл өгүүллийн хэлбэрт оруулан манай зохион байгуулагч нарт аль болох ойрын хугацаанд ирүүлэхийг хүсье.

Төгсгөлд нь та бидний хүчээ нэгтгэн хөгжүүлэхийг оролдож буй “Монголын олон улс судлал” цаашид өргөжин хөгжих болтугай гэсэн ерөөлөөр энэхүү хурлын үйл ажиллагаагаа өндөрлүүлэхийг зөвшөөрнө үү.

Баярлалаа, баяртай.